

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2026 оны 06 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСАГ 2025 ОНД

ДНБ-ий өсөлт

(2025 он)

6.8 хувь

Гадаад валютын нөөц

(2025 он)

7,005 сая \$

Инфляц

(2025 оны 12 дугаар сар)

7.5 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 12 дугаар сар)

-1,232 тэрбум ₮

Экспорт

(2025 он)

15.7 тэрбум \$

Импорт

(2025 он)

11.3 тэрбум \$

ГШХО

(2025 он)

3.8 тэрбум \$

Зээлийн хүү

(2025 оны 12 дугаар сар)

17.2 хувь

Ажиллагчдын тоо

(2025 он)

1.36 сая

\*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.3 хувь байна.

Бодит цалин

(2024 оны 4 дүгээр улирал)

2.4 сая

\*ХҮИ 2023=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 4 дүгээр улирал)

116.8 мянга

\*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 4 дүгээр улирал)

5.0 хувь

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2026.06

ДНБ-ий өсөлт

(2026 оны 5 дугаар сар)

7.3 хувь

Гадаад валютын нөөц

(2026 оны 6 дугаар сар)

7,656 сая \$

Инфляц

(2026 оны 6 дугаар сар)

12.0 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2026 оны 6 дугаар сар)

-2,144 тэрбум ₮

Экспорт

(2026 оны 6 дугаар сар)

10.4 тэрбум \$

Импорт

(2026 оны 6 дугаар сар)

6.1 тэрбум \$

ГШХО

(2026 оны 1 дүгээр улирал)

1.4 тэрбум \$

Зээлийн хүү

(2026 оны 6 дугаар сар)

17.6 хувь

Ажиллагчдын тоо

(2026 оны 1 дүгээр улирал)

1.34 сая

\*1 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 60.4 хувь байна.

Бодит цалин

(2026 оны 6 дугаар сар)

2.4 сая

\*ХҮИ 2023=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2026 оны 2 дугаар улирал)

119.1 мянга

\*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт


(2025 оны 4 дүгээр улирал)

5.0 хувь



Эдийн засгийн өсөлт 2026 оны 5 дугаар сард 7.3 хувьд хүрлээ. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн эрчим өндөр хэвээр байсан нь нийт өсөлтийг тэтгэв. Мөн хөдөө аж ахуйн салбарын өсөлт тогтвортой байж нийт өсөлтийг тэтгэж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ  
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2026 оны 5 дугаар сарын байдлаар **7.3 хувиар өслөө**.
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуй 11.5 хувиар тэлж, өсөлтийн 1.5 нэгж хувийг, уул уурхай 29.2 хувиар тэлж, өсөлтийн 3.7 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар /аж үйлдвэр, барилга/-ын үйлдвэрлэл 2.6 хувиар өсөж өсөлтийн 0.3 нэгж хувийг бүрдүүлэв.
- Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл 4.0 хувиар өсөж, өсөлтийн 1.9 хувийг бүрдүүллээ.
- Харин бүтээгдэхүүний цэвэр татвар 0.6 хувиар агшиж, өсөлтийг 0.1 нэгж хувиар саарууллаа.


ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ  
(салбараар)

| ДНБ                   | 2025.05 |                   | 2026.05 |                   |
|-----------------------|---------|-------------------|---------|-------------------|
|                       | Өсөлт   | Өсөлт дэх оролцоо | Өсөлт   | Өсөлт дэх оролцоо |
|                       | 5.8     |                   | 7.3     |                   |
| Хөдөө аж ахуй         | 36.3    | 3.7               | 11.5    | 1.5               |
| Уул уурхай, олборлолт | 3.1     | 0.4               | 29.2    | 3.7               |
| Аж үйлдвэр, барилга   | 6.8     | 0.7               | 2.6     | 0.3               |
| Үйлчилгээ             | 1.4     | 0.7               | 4.0     | 1.9               |
| Цэвэр татвар          | 1.6     | 0.3               | -0.6    | -0.1              |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эдийн засгийн өсөлтийг уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын өсөлт голлон дэмжсэн байна.
- Барилга, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад саарсан байна.
- Цэвэр татвар буурсан нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй байна.


УУЛ УУРХАЙ  
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Уул уурхайн салбар 2026 оны 5 дугаар сард 29.2 хувиар өслөө.
- Үүнд нүүрс олборлолт 50.5 сая тоннд хүрч, өмнөх оноос 44 хувиар, зэсийн баяжмал үйлдвэрлэл 972 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

ХӨДӨӨ АЖ АХУЙ  
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Хөдөө аж ахуйн салбар 2026 оны 5 дугаар сард 11.5 хувиар өслөө.
- Өвөлжилт харьцангуй хэвийн байсан ч хаврын саруудад зарим нутгаар цас, шороон шуургатай хүйтэн байж, бойжсон төлийн тоо толгой 14.0 саяд хүрч (төл бойжилт 98.9 хувь) өмнөх оны мөн үеэс 820 мянган толгой малаар буурч, том малын зүй бус хорогдол 230.8 мянган толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 114 мянган толгой малаар өссөнөөр хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн эрчим саарах хандлагатай байна.



Өсөлтийг эрэлт талаас цэвэр экспорт, өрхийн хэрэглээ голлон дэмжлээ.

ДНБ-ий өсөлт


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төрийн болон өрхийн хэрэглээний өсөлт


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөрөнгийн хуримтлалын өсөлт


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Экспорт, импортын өсөлт

(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эдийн засгийн өсөлтийг гадаад эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 16.6 нэгж хувийг цэвэр экспорт, 6.4 нэгж хувийг өрхийн хэрэглээ бүрдүүлсэн байна.
- Харин нийт хөрөнгийн хуримтлалын бууралт өсөлтийг 15.0 нэгж хувиар бууруулсан байна.
- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар, өрхийн хэрэглээ 4.9 хувиар тус тус өслөө.
- Үндсэн хөрөнгийн хуримтлал 16.6 хувиар буурахад машин тоног төхөөрөмжийн хуримтлал өмнөх оноос 34.8 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 44.8 хувиар өсөж, өсөлтийн эрчим огцом нэмэгдсэнээр цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж байна.




Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 6 дугаар сард 55.9 хувиар өсөв. Уул уурхайн салбарт нүүрс, зэс, төмрийн хүдрийн олборлолтын биет хэмжээ өссөн нь аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байна.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ  
(тэрбум төгрөг)



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2026 оны 6 дугаар сард 35.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 55.9 хувиар өслөө.
- Нүүрс, металлын хүдэр олборлолт өссөнөөр салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 68.2 хувиар өслөө.
- Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөнөөр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, химийн бодис болон химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нөлөөгөөр боловсруулах салбар (нэрлэсэн дүнгээр) 15.4 хувь өслөө.

НҮҮРС ОЛБОРЛОЛТ  
(сая тонн)



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 80 орчим хувийг\* уул уурхайн салбар, түүний дотор 40 орчим хувийг нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2026 оны 6 дугаар сард 61 сая тонн болж, өмнөх оноос 48.7 хувиар өслөө.


УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ  
(голлох бүтээгдэхүүнээр)

|                |                    |                       |
|----------------|--------------------|-----------------------|
|                |                    | ӨМНӨХ ОНООС ӨӨРЧЛӨЛТ: |
| Зэсийн баяжмал | 1,163 мян.тонн     | 20.0%                 |
| Газрын тос     | 1,761 мян. Баррель | -7.3%                 |
| Алт            | 4.5 тонн           | Өмнөх оны хэмжээнд    |
| Төмрийн хүдэр  | 4.1 сая.тонн       | 21.7%                 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- 2026 оны 6 дугаар сард зэсийн баяжмалын үйлдвэрлэл 20 хувиар өсөж 1,163 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 4.1 сая тоннд хүрч, 21.7 хувиар өссөн байна.
- Алт олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшинд байна.
- Харин газрын тос олборлолт 7.3 хувиар буурлаа.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2024=100)



- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2026 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар өссөн байна.


Үнэ өссөн:

- Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 56.7 хувиар;
- Металлын хүдэр олборлолт 48.8 хувиар;
- Цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 56.7 хувиар;
- Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 32.6 хувиар;


\*2025 оны байдлаар




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 6 дугаар сард бодит дүнгээр 0.3 хувиар буурав. Үүнд мах боловсруулах үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, ундааны үйлдвэрлэл болон металл боловсруулах үйлдвэрлэл буурсан нь голлон нөлөөлсөн хэвээр байна.




- Боловсруулсан малын мах 2026 оны 6 дугаар сард 8.4 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 52.5 хувиар буурлаа.
- Боловсруулсан махны биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 29 хувиар буурлаа.



- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 78.9 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар буурсан байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 10 хувиар буураад байна.




- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 267.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 3 хувиар буурсан байна.




- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2026 оны 6 дугаар сард 1,074 тонн болж, өмнөх оны мөн үеэс 46.4 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөнөөр боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар өссөн байна.




Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, металл бэлдэц, цувимал, вакум цонх, хаалганы үйлдвэрлэл нэмэгдсэн бол катодын зэсийн үйлдвэрлэл буурсан байна.




■ Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 1,018 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар өсөөд байна.



■ Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 3,196 тонн болж, өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар буураад байна.




■ Металл бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 38.4 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өсөөд байна.



■ Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 19.5 мянган м.кв болж, өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар өслөө.



Нүүрс тээвэр нэмэгдсэнээр тээврийн салбарын ачаа тээвэр нэмэгдлээ. Худалдаа, зочид буудал, нийтийн хоолны салбарын инфляцаар засварласан бодит орлого өслөө.



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2026 оны 5 дугаар сард нэрлэсэн дүнгээр 27.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 0.5 хувиар өссөн байна.



- 2026 оны 5 дугаар сард нэрлэсэн дүнгээр зочид буудлын салбарын борлуулалтын орлого 13.5 хувиар өсөж, нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 9.1 хувиар өссөн байна.
- Үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлого 5.4 хувиар өсөж, нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 1.4 хувиар өссөн байна.

**ТЭЭВЭР\***  
(тээсэн ачаа, сая тонн)

|                  | 2025.06 | 2026.05 | ӨМНӨХ ОНООС: |
|------------------|---------|---------|--------------|
| Төмөр зам        | 20.9    | 30.8    | 47.2%        |
| Уул уурхайн бүт. | 14.9    | 23.4    | 57.1%        |
| Агаар*           | 4.62    | 4.68    | 1.2%         |

|                  | 2025.I | 2026.I |       |
|------------------|--------|--------|-------|
| Авто зам         | 18.4   | 28.6   | 55.1% |
| Уул уурхайн бүт. | 12.2   | 18.7   | 52.5% |

\*мянган тонн  
Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик улирлаар зарлагддаг.  
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Төмөр замаар 2026 оны 6 дугаар сарын байдлаар 30.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.2 хувийн өсөлттэй байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 1.2 хувийн өсөлттэй байна.
- Авто замаар\* 2026 оны 1 дүгээр улиралд 28.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 55.1 хувийн өсөлттэй байна.




- 2026 оны эхний зургаан сарын байдлаар Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 417.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өссөн байна. Энэ нь хагас жилийн байдлаар Монгол улсад ирж буй жуулчдын түүхэн дээд хэмжээ юм.




2026 оны 6 дугаар сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 16.5 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 4.3 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

ЭКСПОРТ  
(сая ам.доллар)




- Экспорт 6 дугаар сард 10,394 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 58хувиар өслөө.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүллээ.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ЭКСПОРТ (сая ам.доллар)



- Нүүрсний экспортын орлого 4,016 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 51 хувиар өслөө.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 4,646 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 97 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 449 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 308 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12 хувиар өслөө.

ИМПОРТ  
(сая ам.доллар)



- 2026 оны 6 дугаар сард импорт 6,117 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өссөн байна.
- Нийт импортын 21 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 19 хувийг тоног төхөөрөмж, 13 хувийг барилгын материал, 10 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 8 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Шатахууны импорт 46 хувиар, барилгын материал 17 хувиар, тоног төхөөрөмж 14 хувиар, хүнс 7 хувиар тус тус өссөн нь импортыг нэмэгдүүллээ.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ИМПОРТ (сая ам.доллар)




- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,301 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 46 хувиар өссөн байна.
- Тоног төхөөрөмжийн импорт 1,170 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн байна.
- Суудлын автомашины импорт 489 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 26 хувиар буурлаа.
- Барилгын материалын импорт 789 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн байна.
- Хүнсний импорт 621 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар өслөө.




2026 оны 6 дугаар сард уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспортын биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 59.2 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 56 хувиар өслөө.



- Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 1,307 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 24 хувиар өслөө.



- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 4,355 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 13 хувиар өслөө.



- Газрын тосны экспортын биет хэмжээ 2026 оны 6 дугаар сард 1,707 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 4 хувиар буурлаа.


## 2.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭКСПОРТ

2026.06 сар




2026 оны 6 сард хөдөө аж ахуйн экспорт өмнөх оны мөн үеэс 53 хувиар өслөө.


**ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ  
ЭКСПОРТ**  
(сая ам.доллар)




**ХОНЬ, ЯМААНЫ МАХ**  
(сая ам.доллар)




**САМНАСАН НООЛУУР**  
(сая ам.доллар)



**АРЬС, ШИР**  
(сая ам.доллар)




**БОЛОВСРУУЛСАН МАХ**  
(сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**АДУУ, ҮХРИЙН МАХ**  
(сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**УГААСАН НООЛУУР**  
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**НООС**  
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ  
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс )



- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2026 оны 6 дугаар сарын дундаж үнэ 236 ам.долларт хүрч, өмнөх сараас 2 хувиар, өмнөх оны мөн үеэс 35 хувиар өссөн байна.

ЗЭС

(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2026 оны 6 дугаар сарын дунджаар 13,356 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 38 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүн хойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)



- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2026 оны 6 дугаар дундаж үнэ 100 ам.долларт хүрч, өмнөх сараас 8 хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 8 хувиар өссөн байна.

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



- Брент газрын тосны 2026 оны 6 дугаар сарын дундаж үнэ 79 ам.долларт хүрч өмнөх сараас 13 хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үеэс 25 хувиар өслөө.


# 4. УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

2026.06 сар



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2026 оны 6 сард 14.6 сая тонн нүүрс, 3.0 сая тонн төмрийн хүдэр арилжаалаад байна.

## НҮҮРСНИЙ АРИЛЖАА (сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2026 оны 6 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 73.7 сая тонн нүүрс арилжиж, 7.5 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2025 онд 21.8 сая тонн нүүрс арилжиж, 1.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 6 сард 14.6 сая тонн нүүрс борлууллаа.


## НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2026 оны 6 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 99 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 109 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 6 дугаар сард хэлцлийн доод үнэ 68 ам.доллар, дээд үнэ 166 ам.долларт хүрэв.

## ТӨМРИЙН АРИЛЖАА (мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2026 оны 6 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 12 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 795 сая ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2025 онд 5.9 сая тонн төмрийг арилжаалж, 380 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 6 сард 3.0 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.

## ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж


- Төмрийн хүдэр болон баяжмалын 6 дугаар сарын дуудах дундаж үнэ 67 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 68 ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 6 дугаар сард хэлцлийн доод үнэ 59 ам.доллар, дээд үнэ 94 ам.долларт хүрэв.



Төлбөрийн тэнцэл 2026 оны 5 дугаар сарын байдлаар 537 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2026 оны 6 дугаар сард өмнөх оноос 2.5 сая ам.доллараар өсөж, 7,656 сая ам.долларт хүрлээ.




- Төлбөрийн тэнцэл 2026 оны 5 дугаар сарын байдлаар 537 сая ам.долларын ашигтай байна.
- Урсгал данс 47 сая ам.долларын алдагдалтай байгаа бол санхүүгийн данс 827 сая ам.долларын ашигтай байна.



- Гадаад валютын улсын нөөц 2026 оны 6 дугаар сарын эцэст 7,656 сая ам.доллар болж, өмнөх сараас 77 сая ам.доллараар буурсан бол өмнөх оны мөн үеэс 2,450 сая ам.доллараар өслөө.



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 6 дугаар сард өдөрт дунджаар 0.2 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,580 төгрөгт хүрлээ.



- Төв банк 2026 оны 6 дугаар сард 304 сая ам.долларыг зах зээлд нийлүүлээ.
- Төв банк 2026 оны эхний хагас жилийн байдлаар мөн үеэс 1,361 сая ам.доллараар бага буюу нийт 2,060 сая ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


Тэмдэглэл: Төлбөрийн тэнцлийн статистик 1 сарын хоцрогдолтой зарлагддаг.




Инфляц 2026 оны 6 дугаар сард 12.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар өслөө. Инфляц өмнөх оны мөн үеэс өсөхөд хүнс голлон нөлөөллөө. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 1.0 хувиар өссөн байна.




- Инфляц 2026 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 12.0 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.8 нэгж хувь (22.3 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 9.2 нэгж хувь буюу 77.7 хувийг эзэлж байна.



- 2026 оны 6 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.0 хувиар өслөө.
- Сарын инфляц 1.0 хувь гарахад үхэр, хонь, адууны махны үнэ өмнөх сараас 4.6, 2.2, 6.8 хувиар өссөн нь нөлөөлөв. Мөн түүнчлэн усны төлбөр 14 хувь, цахилгаан болон дулааны төлбөр 5 хувиар нэмэгдсэн нь сарын инфляцад нөлөөлсөн байна.




- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2026 оны 6 дугаар сард суурь инфляц 6.8 хувь гарч, нийт инфляцын 4.1 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 2 сар дараалан өссөн үзүүлэлттэй байна.



- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт эрчимжсэнээр жилийн инфляцын 43.9 хувийг бүрдүүлээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 60.0 хувиар өслөө.




Олон улсад чингэлэг тээврийн үнэ 4,547 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 75 хувиар өслөө. Хүнсний үнийн индекс 2026 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Хүнсний инфляц 2026 оны 6 дугаар сард 24.8 хувь болж, нийт инфляцын 6.8 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц эрчимжихэд махны үнийн өсөлт нөлөөллөө.
- Хүнсний бус инфляц 7.2 хувьд хүрч, нийт инфляцын 5.2 нэгж хувийг бүрдүүллээ.




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 6 дугаар сард дунджаар 3,577 төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2026 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.3 хувиар өслөө.



Эх сурвалж: Drewry World Container Index

- Ойрх Дорнодын мөргөлдөөний дараа харьцангуй тогтвортой өсөлттэй байсан чингэлэг тээврийн үнэ сүүлийн сард огцом өслөө.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2026 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 4,547 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 75 хувиар өссөн байна.
- Чингэлэг тээврийн үнэ өсөж байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.



Эх сурвалж: FAO


- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2026 оны 6 дугаар сард 130.3 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар өссөн бол өмнөх сараас 0.3 хувиар буурсан байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр ургамлын тос, махны үнэ өсөж, элсэн чихэр, үр тариа болон сүүн бүтээгдэхүүний үнэ буурсан байна.




Нэгдсэн төсвийн орлого 2026 оны 6 дугаар сарын байдлаар 16,848.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар, зарлага 16,773.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.0 хувиар өслөө.




- Оны эхнээс АМНАТ-ийн 65 хувийг Ирээдүйн өв санд хуваарилсан нь сангуудын орлогын хуримтлалыг нэмэгдүүлж, өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өсөж 2.2 их наяд төгрөгт хүрсэн байна.
- Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 оны 6 дугаар сарын байдлаар 14.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 их наяд төгрөг буюу 10.7 хувиар өссөн байна.
- Татварын орлого 2026 оны эхний 6 сард 13.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөг буюу 10.3 хувиар өссөн байна. Үүнд, НД болон НӨАТ-ын орлогын өсөлт голлон нөлөөллөө.



- Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ өсөж, түүхий эд бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өндөр байгаатай холбоотойгоор нийт АМНАТ-ын орлого 2.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөг буюу 1.9 дахин өссөн нь төсвийн орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ.
- Харин онцгой албан татварын орлого 114.7 тэрбум төгрөг буюу 20.7 хувиар буурсан байна.



- Нэгдсэн төсвийн зарлага 2026 оны 6 дугаар сард 16.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.8 их наяд төгрөг буюу 20.0 хувиар өссөн байна.
- Нийт өсөлтийн 12.3 нэгж хувийг урсгал зардлын өсөлт, 7.3 нэгж хувийг хөрөнгийн зардлын өсөлт бүрдүүлсэн байна.
- Хөрөнгийн зардал 2.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөг буюу 1.6 дахин өсөхөд барилга байгууламжийн зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна.



- Цалингийн зардал 4.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөг буюу 29.4 хувиар, НД-ын тэтгэвэр тэтгэмжийн зардал 3.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 421.5 тэрбум төгрөг буюу 14.4 хувиар тус тус өссөн нь урсгал зардлын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.
- Засгийн газрын урсгал шилжүүлэг 1,459.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.5 тэрбум төгрөгөөр (1.6%) өсөж, харин бараа үйлчилгээний бусад зардал 457.4 тэрбум төгрөгт хүрч, 55.7 тэрбум төгрөгөөр (10.9%) буурсан байна.

## 7.2 ТӨСВИЙН ТЭНЦЭЛ БА ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР


2026.06 сар



Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 6 дугаар сарын байдлаар 2,143.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

### ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

### ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

(их наяд төгрөг)




Эх сурвалж: Сангийн яам

### ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг)

Баруун тэнхлэг: ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Сангийн яам

### ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг)

|                          | 2025.1 | 2026.1 | Өсөлт/бууралт |
|--------------------------|--------|--------|---------------|
| Засгийн газрын нийт өр   | 34.6   | 35.8   | 3.4%          |
| ДНБ-д эзлэх хувь         | 37.3%  | 37.5%  | 0.2%          |
| Засгийн газрын дотоод өр | 0.4    | 1.1    | 160.8%        |
| Засгийн газрын гадаад өр | 31.4   | 32.0   | 1.9%          |
| Үнэт цаас                | 8.7    | 9.1    | 4.5%          |
| Зээл                     | 22.7   | 22.9   | 0.9%          |
| Засгийн газрын бусад өр  | 2.8    | 2.7    | -2.0%         |
| ЗГ өрийн баталгаа        | 0.2    | 0.2    | -7.9%         |
| Нийслэлийн үнэт цаас     | 2.6    | 2.6    | -1.6%         |

Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 6 дугаар сарын байдлаар 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Уг алдагдалд төрийн албан хаагчдын цалин хөлсний болон хөрөнгийн зардлын өсөлт голлон нөлөөлөө.


- Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2026 оны 6 дугаар сарын байдлаар 75.4 тэрбум төгрөгийн ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс төсвийн ашиг 16.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Төсвийн үндсэн тэнцэл нь нийт зардлаас хүүгийн зардлыг хасаж тооцсон тэнцэл бөгөөд 2026 оны 6 дугаар сард 867.8 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.
- Энэ нь хүүгийн төлбөрийг эс тооцвол төсвийн суурь үйл ажиллагаа ашигтай гарсныг илэрхийлж байна.

- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар 35.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар өсөж, ДНБ-ий 37.5 хувьд хүрсэн байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.


- Засгийн газрын нийт өрийн 89.4 хувийг гадаад өр, үүний дотор 63.9 хувийг гадаад зээл, үлдсэн 25.5 хувийг гадаад үнэт цаас бүрдүүлж байна.
- Нийт өрийн бүтцэд гадаад өр давамгайлж байгаа нь валютын ханшийн хэлбэлзэл, олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хүүгийн түвшний өөрчлөлтөөс шууд хамаарах тул өрийн эрсдэл харьцангуй өндөр байгааг илэрхийлж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 25.8 хувиар өсөж, 53.1 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2026 оны 6 дугаар сард 49.0 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 15.9 хувьд хүрлээ.



- Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 6 дугаар сарын эцэст 53.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.8 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 13.3 нэгж хувь, гадаад валютын хадгаламж ба харилцах 6.7 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.2 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 33.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.8 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 28.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.9 хувиар өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буурлаа.



- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2026 оны 6 дугаар сарын эцэст 49.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.0 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.08 хувиар өслөө.



- Банкнуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 6 дугаар сард 17.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар, өмнөх сараас 0.09 нэгж хувиар тус тус өссөн байна.
- Банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 6 дугаар сард 11.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.5, өмнөх сараас 0.68 нэгж хувиар тус тус буурсан байна.




Банкуудын ногоон зээлийн нийт үлдэгдэл 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар 2.5 их наяд төгрөгт хүрч, өмнө улирлаас 2.9 хувиар нэмэгджээ. Банкуудын нийт зээлийн үлдэгдэлд ногоон зээлийн эзлэх хувь 5.7 хувьд хүрлээ.

НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН ӨСӨЛТ (улирлын өсөлт, хувь)




- 2026 оны I улирлын байдлаар ногоон зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 9.2 хувиар өсөж, өсөлтийн эерэг хандлага үргэлжилж байна. Хэдий 2022-2023 оны огцом өсөлттэй үеэс харьцангуй саарсан ч ногоон санхүүжилт банкны салбарт тогтвортой байр суурь эзэлж эхэлж буйг харуулж байна.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ (хувь)



- Ногоон зээлийн чанаргүй зээлийн хувь 2.1 хувь байгаа нь банкны системийн дундаж болох 5.1 хувиас харьцангуй бага түвшинд байна. Сүүлийн жилүүдэд ногоон зээлийн чанаргүй зээлийн хувь тогтвортой буурсан нь уг төрлийн санхүүжилтийн эрсдэл харьцангуй бага, чанарын үзүүлэлт илүү сайн байгааг харуулж байна.

НИЙТ ЗЭЭЛД НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН ЭЗЛЭХ ХУВЬ (хувь)



- Ногоон зээлийн үлдэгдэл нийт зээлийн 5.7 хувийг эзэлж, сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн байна. Гэсэн ч банкны салбарын нийт зээлийн багцтай харьцуулахад ногоон зээлийн хэмжээ харьцангуй бага хэвээр байгаа нь ногоон санхүүжилтийн орон зай цаашид тэлэх боломжтойг харуулж байна.

НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ (салбараар, хувь)




- 2026 оны I улирлын байдлаар ногоон зээлийн үлдэгдлийн дийлэнх буюу 58.8% нь эрчим хүчний хэмнэлтийн чиглэлд төвлөрч байна. Мөн тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлалын салбар 18.2 хувийг эзэлж байгаа бол сэргээгдэх эрчим хүчний салбарын эзлэх хувь 8.9% байна. Энэ нь ногоон санхүүжилт харьцангуй цөөн чиглэлд төвлөрч, бусад ногоон салбаруудын санхүүжилтийн орон зай харьцангуй бага хэвээр байгааг харуулж байна.



Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 14.1 хувь, жигнэсэн дундаж хугацаа 54.0 сар байна. Ногоон төгрөгийн зээл нь банкны зээлтэй харьцуулахад бага хүүтэй, урт хугацаатай олгогдож байгаа нь тогтвортой, урт хугацааны ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих хандлага нэмэгдэж байна.


ШИНЭЭР ОЛГОСОН ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮ (жигнэсэн дундаж хувь, жилээр)



Эх сурвалж: Монголбанк

■ Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 14.1 хувь байгаа нь банкны зээлийн дундаж хүү болох 17.4 хувиас доогуур түвшинд байна. Сүүлийн жилүүдэд ногоон зээлийн хүү нийт банкны зээлийн хүүгээс харьцангуй бага хадгалагдаж байгаа нь ногоон санхүүжилтийг илүү таатай нөхцөлөөр дэмжих хандлага үргэлжилж байгааг харуулж байна.

ШИНЭЭР ОЛГОСОН ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ХУГАЦАА (жигнэсэн дундаж хугацаа,сар)



Эх сурвалж: Монголбанк

■ Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа 54.0 сар байгаа нь банкны зээлийн дундаж хугацаа болох 38.7 сараас урт байна. Ногоон зээлүүд харьцангуй урт хугацаатай олгогдож байгаа нь эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хөрөнгө оруулалт зэрэг урт хугацааны өгөөжтэй төслүүдийг санхүүжүүлэх хандлага нэмэгдэж байгааг илтгэж байна.

НОГООН БОНДУУДЫН МЭДЭЭЛЭЛ- 2026.03

Арилжааны банк (2023.12.15)

НОГООН БОНД - 1

17 тэрбум ₮

16% | 3 жил

Арилжааны банк (2024.10.17)

НОГООН БОНД - 2

25 сая \$

SOFR+3.4% | 3 жил

Хог хаягдлыг дахин боловсруулах салбар (2024.11.06)

НОГООН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫН БОНД (ТРАНЧ-1)

11 сая \$

10% | 3 жил

Хог хаягдлыг дахин боловсруулах салбар (2025.01.03)

НОГООН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫН БОНД (ТРАНЧ-2)

4 сая \$

10% | 3 жил

Арилжааны банк (2024.10.23)

БАТАЛГААЖААГҮЙ НОГООН БОЛОН НИЙГМИЙН БОНД

50 сая \$

9.5% | 5 жил

Арилжааны банк (2025.01.02)

НОГООН БОЛОН НИЙГМИЙН БОНД

50 сая \$

8% | 5 жил



Ажиллагчдын тоо 1 сая 340 мянга болон буурч, улмаар ажиллах хүчний оролцооны түвшин 60.4 хувь болов.





Өрхийн бодит орлого 6.3 хувиар өслөө.

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ  
(хувь)

ХАА-н орлого

Тэтгэвэр, тэтгэмж

Цалин хөлс

Бусад орлого

Өрхийн бодит орлого

| Он   | Өсөлт (хувь) |
|------|--------------|
| 2022 | -1.2         |
| 2023 | 1.5          |
| 2024 | 3.8          |
| 2025 | 2.1          |
| 2026 | 6.3          |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА  
БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ  
(хувь)

Зарлага

Хадгаламж

Орлого

| Он   | Орлого | Зарлага | Хадгаламж |
|------|--------|---------|-----------|
| 2022 | -10.5  | 5.2     | -1.2      |
| 2023 | 12.1   | 15.8    | 3.4       |
| 2024 | 18.3   | 18.5    | 10.2      |
| 2025 | 15.7   | 16.1    | 12.5      |
| 2026 | 14.2   | 15.3    | 13.8      |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО  
(хувь)

1.1 сая хүртэл

2.1-4.0 сая

1.1-2.1 сая хүртэл

4.0 саяас дээш

| Он   | Улсын дундаж | Нийслэл | Хөдөө |
|------|--------------|---------|-------|
| 2023 | 33.3         | 36.4    | 21.0  |
| 2024 | 45.4         | 34.1    | 15.2  |
| 2025 | 16.3         | 42.0    | 29.0  |
| 2026 | 12.6         | 12.6    | 12.6  |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО  
(сая төгрөг)

2023 I

2024 I

2025 I

2026 I

| Он   | Улаанбаатар | Сумын төв | Хөдөө |
|------|-------------|-----------|-------|
| 2023 | 3.25        | 2.44      | 2.25  |
| 2024 | 4.17        | 2.89      | 2.66  |
| 2025 | 2.89        | 2.44      | 2.25  |
| 2026 | 2.66        | 2.25      | 2.25  |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Өрхийн бодит орлогын өсөлтийн эрчим өмнөх улирлаас сайжирч, 6.3 хувиар өсөв\*.

Өрхийн орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс нэрлэсэн дүнгээр 224.0 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 80.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Өрхийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс дээгүүр байгаа хэдий ч иргэдийн хадгаламжийн өсөлт үргэлжлэн удааширсаар байна.

Хөдөөгийн өрхийн 42 хүртэлх хувь, нийслэлийн өрхийн 20 орчим хувь 2.1 сая төгрөг хүртэлх орлоготой байна.

Хөдөөгийн өрхийн 16 хувь нь 4 сая төгрөгөөс дээш орлоготой байгаа бол нийслэлийн өрхийн 45 хувь нь 4.0 сая төгрөгөөс дээш хэмжээний орлоготой байна.

Хот, хөдөөгийн нэрлэсэн орлогын зөрүү хадгалагдаж байна. Үүнд, 2025 оны 1 дүгээр улиралд нийслэлийн өрхийн дундаж орлого хөдөөгийн өрхөөс 1.5 дахин өндөр байсан бол 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар зөрүү хадгалагдаж, 1.6 гарлаа. Хөдөөгийн өрхийн орлогын өсөлтийн эрчим нэмэгдэж байгаа ч орлогын зөрүү хадгалагдсаар байна.

Тэмдэглэл: ҮСХ-ноос өрхийн бодит орлогыг 2026 оны I улирлаас 2023 оны зэрэгцүүлэх үнээр тооцож эхэлсэн, 2021 улирлаас - 2025 оны IV улирлын бодит орлого нь 2020 оны зэрэгцүүлэх үнээр тооцогдсон.

Тэмдэглэл: ҮСХ-ноос өрхийн бодит орлого, зарлагыг 2026 оны I улирлаас 2023 оны зэрэгцүүлэх үнээр тооцож эхэлсэн. 2022 I улирлаас - 2025 оны IV улирлын бодит орлого, зарлага нь 2020 оны зэрэгцүүлэх үнээр тооцогдсон.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2026 оны 2 дугаар улиралд 274.2 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 2.8 мянгаар буюу 9.5 хувиар өслөө.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО

(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)

■ Үйл ажиллагаа явуулж буй болон эхлээгүй

■ Үйл ажиллагаа зогсоосон болон олдохгүй байгаа

|       |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|-------|
| 2021  | 2022  | 2023  | 2024  | 2025  | 2026  |
| 110.3 | 121.3 | 136.1 | 135.4 | 158.4 | 173.5 |
| 103.7 | 116.2 | 119.4 | 110.2 | 113.0 | 100.7 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

(ААН-ийн тоо, салбараар)

|                 |      |
|-----------------|------|
| Үйлчилгээ ба... | 2496 |
| Худалдаа        | 2456 |
| Хөдөө аж ахуй   | 481  |
| Барилга         | 458  |
| Боловсруулах    | 443  |
| Тээвэр          | 357  |
| Уул уурхай      | 32   |
| Цахилгаан, ус   | 22   |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО

(мянга, ажиллагчдын тоогоор)

■ 1-9

■ 10-19

■ 20-49

■ 50 ба түүнээс дээш

|      |      |      |      |      |      |
|------|------|------|------|------|------|
| 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
| 65   | 73   | 82   | 89   | 97   | 104  |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

(улирлаар, 2018=100)

— ХИИ

— Өнөөгийн байдал

— Ирээдүйн хүлээлт

|       |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|-------|
| 2021  | 2022  | 2023  | 2024  | 2025  | 2026  |
| 107.2 | 107.7 | 107.2 | 107.7 | 107.2 | 107.7 |

Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

■ Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2026 оны 2 дүгээр улиралд 274.2 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 2.8 мянгаар өслөө.

■ Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-үүд өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар нэмэгдсэн бол, үйл ажиллагаа зогсоосон болон олдохгүй байгаа аж ахуйн нэгжүүд 10.8 хувиар буурсан байна.

■ Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо буурсан хэдий ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж буй нь эдийн засгийн идэвхжилттэй байгааг харуулж байна.

■ Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо худалдааны салбарт 2.4 мянга, үйлчилгээний салбарт 2.5 мянгаар нэмэгдлээ.

■ Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 10.6 хувиар өссөн байна.

■ Үйл ажиллагаа явуулж буй 119.1 мянган ААН-ийн 103.6 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.

■ Мөн 1-9 ажилтантай жижиг ААН-үүд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.8 хувиар өссөн байна.


■ Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2026 оны 1 дүгээр улиралд 107.2 болж өмнөх оны мөн үеэс 2.8 нэгжээр өслөө.

■ ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 2.1 нэгжээр буурсан.

■ Мөн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 10.5 нэгжээр өссөн бөгөөд үүнд бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлт өссөн нь нөлөөллөө.



ОХУ-ын эдийн засаг 2026 оны 1 дүгээр улиралд 0.2 хувиар агшлаа. Инфляцын түвшин 2026 оны 6 дугаар сард 6.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.4 нэгж хувиар буурсан байна.




ОХУ-ын эдийн засаг 2026 оны 1 дүгээр улиралд -0.2 хувиар агшиж, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурлаа.



2026 оны 5 дугаар сарын байдлаар экспорт 42.9 тэрбум ам.доллар, импорт 28.7 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 14.2 тэрбум ам.долларын ашигтай байна.

Экспорт 2026 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 28.2 хувиар өслөө.

Импорт 2026 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар өслөө.




ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.

Инфляцын түвшин 2026 оны 6 дугаар сард 6.0 хувь болж, өмнөх сараас 0.7 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 3.4 нэгж хувиар буурсан байна.

Жилийн инфляцын түвшин 2025 онд 8.7 хувьд хүрч, өмнөх оноос 0.3 нэгж хувиар өслөө.

ОХУ-ын төв банкнаас 4 дүгээр сарын 27-ны өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 14.25 хувьд хүргэх шийдвэр гаргасан.




Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2026 оны 6 дугаар сард 50.3 болж, өмнөх сараас 1.5 нэгжээр өслөө.

Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2026 оны 5 дугаар сарын байдлаар -0.7 хувь болж, өмнөх сараас 2.6 нэгж хувиар буурлаа.



Дотоод эрэлт сул хэвээр байгаа ч нийлүүлэлтийн тогтвортой өсөлтийг хадгалж, экспорт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2026 оны эхний хагас жилд 4.7 хувиар өслөө.

## ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ (хувь)




Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- БНХАУ-ын эдийн засаг 2026 оны 2 дугаар улиралд 4.3 хувиар өсөж, эхний хагас жилийн өсөлт 4.7 хувьд хүрлээ.
- 2026 оны 6 дугаар сард экспорт 27.0 хувиар, импорт 36.0 хувиар тус тус өсөж өмнөх сараас чангарсан үзүүлэлттэй байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.

## АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ (хувь)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн гарц 2026 оны 6 дугаар сард 5.3 хувиар өссөн нь өмнөх сарын өсөлтөөс 0.8 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт оны 6 дугаар сард 1.0 хувь болж өссөн байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.


## ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- Хэрэглээний үнийн индекс 2026 оны 6 дугаар сард 1.0 хувьд хүрч өнгөрсөн сартай харьцуулахад 0.3 хувиар буурсан байна.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2026 оны 6 дугаар сард 4.1 хувь гарч, үнийн уналтын бүсээс гарлаа.

## ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2026 оны 6 дугаар сард 50.3 болж, тэлэлтийг илэрхийлж байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас өсөж 50 түвшинд байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжилтийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ